

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай

2016-12-05 00:00:00

2016 оны 12 сарын 05
А/849

Дугаар
Улаанбаатар хот

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 99 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын зохион байгуулалтын бүтцийг доор дурдсанаар баталсугай:

- 1) Захиргаа, санхүүгийн алба;
- 2) Маркетингийн алба;
- 3) Төхижилт, үйлчилгээний алба.

2. “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын орон тооны хязгаарыг хавсралт ёсоор тогтоосугай.

3. “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын өмч хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авах ажлыг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /Ч.Однасан/-т, үйл ажиллагааны зардлыг хянаж, жил бүрийн нийслэлийн төсвийн төсөлд тусгаж байхыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН
БӨГӨӨД
ХОТЫН ЗАХИРАГЧ

ЗАСАГ ДАРГА
УЛААНБААТАР
С.БАТБОЛД